

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ганбаатар	Дугаар	L182
Оршин суугаа аймаг	Говь-Алтай аймаг	Оршин суугаа сум	Дарви
Төрсөн газар	Баян-Уул сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Засаг даргын тамгын газрын дарга		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дархан гүний хүрээ	Сүм хийдийн дугаар	ГАДР 110
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 29	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Говь-Алтай аймгийн Дарви сумын Дархан гүний хүрээ

Асуулт:-Та тус сумын нутагт оршиж байсан Дархан гүнийн хүрээний **Эрдэнэбэйсийн** хүрээний тухай ярьж өгнө үү.

Хариулт:-Говь-Алтай аймгийн Дарви суманд дээр цагт Засагт хан аймагт 17-р зууны эцэс, 18-р **зууны** эхээр бурхан шашны хүрээ хийд байгуулагдаж эхэлсэн түүхтэй. Засагт хан аймагт хамгийн анх байгуулагдсан хоёр хийдийн нэг нь **Эрдэнэ засгийн** хошуунд байгуулагдсан гэж үздэг. Бэйсийн зэрэг, **Эрдэнэ засаг** улсын түшээ гүн, Гүнсэнгийн хошуу, Энх-Амгалангийн 35-р он буюу 1696-р онд бэйс Самбуудоржийн үед **цогчэн** хурлын сургуулийг анх үүсгэн тогтоосон түүхтэй. Бадаргуулт төрийн 2-р он буюу 1876 онд засаг улсын түшээ гүн Аюурсэд Жамцын **дүйнхэрийн** хурлын сургуулийг үүсгэн тогтоосон гэж үздэг. Бадаргуулт төрийн 4-р он буюу 1878 онд мөн засаг улсын түшээ гүн Аюурсэд **Данзанжанцангийн** үед **цанид** хурлын сургуулийг үүсгэн хүржээ гэсэн ийм түүх байдаг. Эдгээр хурал сургуулийн хүрээ, Баясгалантын ар хэмээх газар нутаглаж байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Анхны хурал номын газар нь Цогчэн хурал гэж байсан байна. Анхны хурал дацан байгуулагдсанаас хойш даруй 180 жилийн дараа **дүйнхэр** хурлын дацантай болсон гэж үздэг. Дүйнхэр хурлын сургууль нь **бурханы** шашны ёс, тооны ухаан, одон зурхай, мэргэ, төөрөг, төлөг, сарын зурхай мэдэл, үйлдэл мэргэжил, мөн найруулга зүй зэргийг сурч судалдаг сургууль байсан нь тогтоогдсон. Энэ сургууль төгсөгчид **зээрэмбэ** гэдэг цолыг олгодог байсан. Дүйнхэр **дацанг** сүмийн да лам нь ахалдаг ёстой байсан байна.

Хамгийн сүүлд **цанид дацанг** байгуулсан гэж үздэг. **Цанид дацанг** бас **чойр** дацан ч гэж нутгийн хөгшид ярьдаг. **Цанид** гэдэг нь төвдөөр бэлэг чанар гэсэн утгатай үг гэж монгол хэлэнд тайлбарлагдаж байна. **Цанид** дацанд **бурханы** шашны гүн ухааны номыг асуулт, хариултын журмаар 13 анги, дамжаа ахиж дамжин суралцдаг байсан нь тодорхой байна. Үүнийг дүүргэсэн ламд 10 бэрхийг туулсан гэсэн утгатай гавж цолыг олгодог байсан. Лам нар **чойрын 5 боть буюу** учир шалтгааны ухаан, бэлэг **баримадын** гүн ухаан, төв үзлийн гүн ухаан, **авидармын** онол, **винайн** ухаан зэрэг ном уншиж судалдаг байсан нь хөгшдийн яриа, түүх шастираас мэдэгддэг. 1918 оны хүн ам, мал хөрөнгө, сүм хийд лам нарын тооллогоор тус хошуунд нийт хүн ам нь 2078 байсны 387 нь лам банди нар байжээ гэж үздэг. Үүнээс 5 жилийн дараа 1923 оны нэгэн мэдээгээр лам банди нар нь 229 болон цөөрсөн байдаг. Үүний гол хүрээ нь Баясгалантын ар хэмээх газарт байсан. Мөн Дарвийн нурууны нутаг Хар чулууны хөндий, **Хуйтангийн** хөндий гэдэг газруудад дацан, **Хуйтангийн** барилгын туурь хадгалагдан үлдсэн нь өнөөг хүртэл түүх соёлын дурсгал болон үлдсэн байдаг.

Дарви суманд 1934-1935 оны үед **дүйнхэр** жас, зарим **баримтанд** Дарвийн жас гэж байдаг. Дарвийн **хуйтан**, **Ихэсийн хуйтан**, Дархан гүний **хуйтан** гэсэн гурван **хуйтан**, нэг жас бүртгэгдсэн байдаг. Эдгээрээс үзэхэд нийтдээ 1935 онд 150 төгрөгийн татвар хураасан баримт байдаг. Цахир жасын орлого нь 1935 онд 350 төгрөг, Дарвийн **хуйтангийн** жасын орлого нь 360 төгрөг, **Ихэсийн хуйтангийн** жасын орлого нь Дархан гүний **хуйтангийн** жасын орлого нь одоогоор тодорхойгүй байна. **Цахирын** жас 12, Дарвийн **хуйтан** 130, **Ихэсийн хуйтан** 27, Дархан гүний **хуйтан** 10 төгрөгийн үнэ бүхий барилгатай байсан нь одоогийн байдлаар тогтоогдоод түүх болон үлдсэн.

Эндээс харахад тус суманд сүм хийдийн мал хөрөнгө тун ядуухан, сүм хийдийн оршин тогтнох эдийн засгийн үндэс бас нэлээн хүндхэн байсан нь харагдаж байгаа. Энэ эдийн засгийн хувьд бас нэлээн багасах талдаа орж, мөн лам банди нар хар болох, 1937-1939 оны баривчилгаа, **хэлмэгдүүлэлтэнд** өртөх зэргээр лам, шавь банди нар тарж, **Эрдэнэбэйсийн** хошуу хожим Дарви сумын нутагт байсан сүм хийд хаагдан оршин тогтнохоо больсон гэсэн ийм түүхийн баримтууд сум орны хэмжээнд өнөөдрийн байдлаар мөрдөгдөж, түүх домог болон яригдаж **баталгаатайгаар** явагдаж байгаа нь тогтоогдсон юм.